

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ПАСПОРТЖУУЛАХ,
АШИГЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРМЫН ТӨСӨЛ БЭЛТГЭХ
ЯВЦАД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Д/Д	Нөхцөл байдал	Хариулт
1	Акт гаргах үндэслэл, шаардлага, зорилтыг тодорхойлох	<p>“Барилгын тухай” хуулийг /шинэчилсэн найруулга/ 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажилласан ба энэ хуулийн 8 дугаар бүлэг “Барилга байгууламжийн гэрчилгээ” нь 48 дугаар зүйл “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах”, 49 дүгээр зүйл “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ, паспортжуулалт” гэсэн 2 зүйлээс бүрдэж байна. Хуулийн 49.5 дахь хэсэгт “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журмыг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн өөрчлөлтийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр оруулсан байна.</p> <p>Үүнтэй уялдуулан Шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 129 дүгээр тушаалаар баталсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг шинээр боловсруулах шаардлага зүй ёсоор тулгарч байна. Журмыг шинэчлэн боловсруулснаар барилга байгууламжийн бат бэх, найдваршил, аюулгүй байдлын түвшинг тогтоож иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг хангах, иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учруулах аюулаас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.</p>
2	Тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ	<p>Акт нь 9 бүлэг, 48 зүйлээс бүрдэж байгаа ба Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглаж байгаа 2002 оноос өмнө баригдсан бүх төрлийн барилга байгууламжийг паспортжуулах, шинээр барьсан, ашиглаж байгаа, өргөтгөж шинэчилсэн, засварлаж тоноггосон барилга байгууламжид чанар, аюулгүй байдлын түвшингээр ашиглалтын гэрчилгээ олгох үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.</p> <p>Монгол Улсын нутаг дэвсгэрт өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 2002 оноос өмнө баригдаж ашиглагдаж буй бүх төрлийн барилга байгууламж болон шинээр баригдсан ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлтээр ашиглалтад орсон бүх төрлийн барилга байгууламжуудад үйлчилнэ.</p>

3	Акт гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлгийг тодорхойлох	Акт гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэг нь орон сууцны барилгад оршин суугч иргэд буюу тухайн барилгыг өмчлөгч, эзэмшигчид, мөн паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтээр тухайн барилга газар хөдлөлтийг тэсвэрлэхгүй болох нь тогтоогдсоноор тухайн иргэдийн амьдарч буй орон сууцны үнэ цэнэ буурч, амьдралын чанарт өөрчлөлт орж болзошгүй.
4	Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх	Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа зүйлгүй гэж үзэж байна. Журмаар тогтоосон хугацаанд өмчлөгчийн хүсэлтэд албан ёсоор хариу өгсөн нөхцөлд дээрх байдал үүсэхгүй гэж үзэж байна.
5	Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх	Энэхүү асуудлыг Барилгын тухай хуулийн 8 дугаар “Барилга байгууламжийн гэрчилгээ” бүлэг нь 48 дугаар зүйл “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах”, 49 дүгээр зүйл “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ, паспортжуулалт”, мөн Шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 129 дүгээр тушаалаар баталсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-аар зохицуулагдаж байна.
6	Актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо	Актыг хэрэгжүүлэхэд аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, сургах, мэргэшүүлэх, багаж хэрэгслэл, техник тоног төхөөрөмжөөр хангах, паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах хуулийн этгээдийн судалгаа, шинжилгээний ажлын зардлын өртөг, мөн барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээг хэвлүүлэх, олгох ажилтны зардал, мөн паспортжуулалтын орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүний цалин хөлс, бичиг хэргийн зардал, паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтээр газар хөдлөлтийг тэсвэрлэхгүй болох нь тогтоогдсон барилга байгууламжийг буулган дахин төлөвлөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхэд жилд ойролцоогоор 2-5 тэрбум төгрөг зарцуулах урьдчилсан тооцоог гаргаад байна.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗАР

